



ОНЛАЙНААР ДАНС НЭЭХ ХҮСЭЛТИЙН ЗААВАР

1. Та <http://onlinerequest.ckbank.local> хаягаар нэвтрэн орж бүртгэлээ и-мэйл хаягаа оруулна.
2. Таны оруулсан и-мэйл хаяганд манай банкнаас нэвтрэх нууц кодыг илгээнэ. Тухайн кодыг нууц код оруулах хэсэгт бичсэнээр бүртгэлийн хэсэгрүү шилжинэ.
3. Бүртгэлийн хэсэгт та хувийн мэдээллээ оруулан анкетыг үнэн зөв бөглөж, дансны төрлөө сонгон, үйлчилгээний гэрээтэй танилцаж зөвшөөрөн хүсэлтийг илгээж болно.
4. Хэрвээ та бүртгэлийн хэсгийг дутуу бөглөсөн тохиолдолд тантай манай банкны Callcenter-ээс холбогдон бүртгэлийн хэсгийг дуусгахад тусламж үзүүлнэ.
5. Таны илгээсэн хүсэлтийг хүлээж авмагцаа ebank@ckbank.mn гэх манай банкны и-мэйл хаягаас танд хариу мэдэгдэнэ.
6. Та банкнаас и-мэйлээр ирсэн зааврын дагуу баримтуудыг хэвлэн авч Монгол Улсад суугаа бол нотариатаар, гадаад улсад суугаа бол оршин суугаа улсынхаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газраар баталгаажуулан, бичиг баримтын баталгаажуулсан хуулбарын хамт баталгаат шуудангаар Банкны заасан хаягт илгээнэ. Үүнд:
 - Харилцагчийн бөглөсөн мэдээлэл бүхий анкетад баталгаат гарын үсгээ зурж, нотариатаар баталгаажуулах;
 - Цахим үйлчилгээний ерөнхий гэрээг 2 хувь хэвлэж, гарын үсгээ зурах;
 - Онлайн түр дансны гэрээг 2 хувь хэвлэж, гарын үсгээ зурах.
 - Гадаад паспорт, цахим иргэний үнэмлэхээ нотариатаар баталгаажуулах.
7. Таны илгээсэн баталгаат шууданг хүлээн авсны дараа ажлын 2 хоногт багтаан таны онлайн дансыг нээж өгөх бөгөөд танд интернэт банкны эрхийг мөн өгөх юм. Та дансаа интернет банкаар дамжуулан ашиглах боломжтой болно.
8. Онлайнгаар данс нээлгэснээр хойш 1 сарын дотор мөнгө байршуулан идэвхжүүлэх юм. Хэрвээ 1 сарын дотор дансанд мөнгө байршуулаагүй тохиолдолд дансыг хаах болно.